



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/34

Чингис хот

“Өсвөр үеийн шигшээ баг”-ийн спортын
нэр төрлийг тогтоож, зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 02 дугаар тогтоол, 2017 оны “Эрүүл мэнд-хөдөлгөөн-хөгжил” дэд хөтөлбөр батлах тухай 08 дугаар тогтоол, 2017 оны “Журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Өсвөр үеийн шигшээ баг”-ийн тамирчдын 2020 оны шигшээ багийн төсвийг нэгдүгээр, дасгалжуулагчийн цалингийн төсвийг хоёрдугаар, спортын нэр төрөл, тоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 88 000000 /наян найман сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

3. Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган, хичээл сургуулилт, ажлын үр дүнг улирал бүр тооцон хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг Биеийн тамир, спортын газар /Г.Нэргүйбаатар/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



231010186

Аймгийн Засаг даргын 2020 оны
 дугаар сарын 11 өдрийн 458
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Хэнтий аймгийн өсвөр үеийн шигшээ багийн 2020 оны төсвийн хуваарь


№	Зардал	жилийн төсөв	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Цалин	71,340,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000	5,945,000
2	НДШ	8,917,500	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125	743,125
3	Томилолт	2,385,000	397,500	397,500	397,500	397,500	397,500	397,500						
4	Уралдаан тэмцээний зардал	5,000,000			5,000,000									
5	Материал, хэрэглэл	357,500	357,500											
6	Дүн	88,000,000	7,443,125	7,085,625	12,085,625	7,085,625	7,085,625	7,085,625	6,688,125	6,688,125	6,688,125	6,688,125	6,688,125	6,688,125

Аймгийн Засаг даргын 2020
дугаар сарын 18 өдрийн 1/1
кирамжийн хоёрдугаар хавс
ан

Хэнтий аймгийн өсвөр үеийн шигшээ багийн 2020 оны цалингийн сан

[illegible]

Аймгийн Засаг даргын 2020 оны
..... дугаар сарын өдрийн
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



“Өсвөр үеийн шигшээ баг”-ийн
спортын нэр төрөл, тоо

1. Бадминтон
2. Буудлага
3. Бокс
4. Волейбол
5. Даам
6. Жүдо бөх
7. Сагсан бөмбөг
8. Чөлөөт бөх
9. Үндэсний бөх
10. Унадаг дугуй
11. Шатар
12. Хөнгөн атлетик
13. Хүндийн өргөлт
14. Хоккей